

FICHE EXPLICATIVE IRM EN MONGOL



Мэдээллийн хуудас

M.R.I. – Цөмийн Оношлогооны Аппарат гэж юу вэ? M.R.I. нь Соронзонгийн Үелзлийн Дүрс Бичлэг гэсэн утгатай. Энэ нь хүний бие махбодийн маш нарийвчилсан дүрс бичлэгийг рентгены долгионуудын тусламжгүйгээр хийх боломжийг олгодог техникийн арга барилын нэг юм. M.R.I. нь усны молекулуудын соронзон чадлын үндсэн зарчим дээр оршин хийгддэг. Уг аппарат нь маш их хүчтэй соронзон талбайг хэрэглэдэг.

Энэ нь сүүлийн жилүүдэд гарч ирсэн аппарат бөгөөд үе мөч, тархи, нугас, ясны чөмөгний өвчнийг ажиглан оношлох чадвартай юм. Мөн M.R.I. – г элэг, бөөр г.м. хүний дотор эрхтнүүдийг шинжлэхэд хэрэглэдэг ба артерийн судсуудыг харан ажиглахад мөн адил хэрэглэдэг байна. M.R.I. Шинжилгээ нь өвдөлтгүй, хоердогч хүндрэл ба өөрчлөлт өгдөггүй давуу талтай бөгөөд харин соронзонгийн талбайн хүчнээс хамааран шинжлүүлж буй өвчтний бие махбодид дор дурьдагдсан төмөр биесийг суулгасан байхыг хориглодог. Үүнд: зүрхний стимулятор - пейс-мейкер зарим зүрхний хиймэл аппаратууд нүдэнд буюу тархин дахь метал, төмрөн гадны биес зэрэг орно.

Таныг хүрэлцэн ирэхэд таны биенд буй бүх метал төмөр зүйлсийг тусгай тасалгаанд тавих шаардлага тавигдана. Үүний дараа таныг шинжилгээний өрөө рүү дагуулан оруулна. Шинжилгээ нь хэвтээ байдалд явагддаг бөгөөд хүний биеийг зориулалтын цагираган аппаратанд оруулах боломжтой тусгай орон дээр дээшээ харж хэвтсэн байдлаар хийгддэг. Шинжилгээний явцад та ганцаараа шинжилгээний өрөөнд байх бөгөөд бид тантай зориулалтын микрофоноор ярилцана. Шинжилгээний явцад бид таныг шилний цаагуур ажиглан харах боломжтой. Шинжилгээ нь өвдөлтгүй, гэхдээ заримдаа чимээ ихтэй байж болно. Шинжилгээний явцаас шалтгаалан зарим тохиолдолд тохойн нугалаанд тариа хийдэг.

Хүний бие организмд явагдаж буй бүх төрлийн үзлэг шинжилгээ нь нарийн мэргэжлийн хамт олноор хийгдэж буй ч гэсэн ямар нэгэн хүндрэл өгөх боломжтой. Үүнд: Тариа хийхэд бага зэргийн цус хуралт үүсэж болзошгүй, тэр нь хэдэн хоногийн дараа арилдаг. Тариа хийх явцад уг тариа нь арьсан дор тархах хүндрэл гарч болзошгүй. Энэ хүндрэл нь маш ховор бөгөөд гадны эмчилгээ шаардагддаг. Шинжилгээний үед хэрэглэгддэг Гадолинум - (Gadolinium) гэх контраст бодист эмийн харшил өгөх буюу эмийг хүлээж авахгүй урвал маш ховор тохиолддог.

Дараачийн хуудсанд буй асуултуудыг бөглөнө үү



FICHE EXPLICATIVE IRM EN MONGOL

Доорхи асуултанд хариулна уу

Та зүрхэндээ жижиг зай , стимулятор эсвэл пейс-мейкер суулгасан уу? тийм үгүй

Та зүрхнийхээ том судсанд мэс засал хийлгэж байсан уу ?тийм үгүй Та ямар нэгэн металл, төмөр зүйлсээр , жишээлбэл, төмрөн гадны биет,сум, төмрийн хог гэх мэтээр олон жилийн өмнө нүд эсвэл нүдний орчим гэмтэж байсан уу?

тийм үгүй Та төмөр зүйлстэй ажиллаж байсан уу?

тийм үгүй

Та шүдний протезаас өөр ямар нэгэн метал, төмөр протез зүүдэг үү?

тийм

үгүй

Та лифтээр явахаас айдаг уу?

тийм үгүй

Та жирэмсэн үү, эсвэл жирэмсэн байх магадлалтай юу?

тийм үгүй

Та хүүхдээ хөхүүлж байгаа юу ?

тийм үгүй

Та арьсан дороо ямар нэгэн наалт, патч зүүдэг үү?

тийм үгүй

Та өөрийн мэдэх бөөрний дутагдалтай юу?

тийм үгүй

Шинжилгээнээс хэдэн хоногийн өмнө танд эмийн жор бичиж өгсөн

тохиолдолдЭмийн сангаас контраст бодис гадолинийм (gadolinium)–ыг авчирна уу (энэ тохиолдолд жор хавсарна)

Шинжилгээ хийх өдөр авчрах зүйлсбидний бичиж өгсөн эмийг эмийн сангаас худалдан аван авчрахөөрийн радио цацраг, рентген шинжилгээний хариууудсыг бөглөн гарын үсгээ зурсан байх ёстой

Шинжилгээ хийгдэх өдөр :

Хоол идэлгүй, өглөөний ундаа уулгүй өлөн ирнэ, шинжилгээ хийхээс 6 цагийн өмнөөс юм идээгүй, уугаагүй, тамхи татаагүй байх ёстой.

Ноен, Хатагтай _____он сар өдөр_____ уг хуудсыг бөглөж, шинжилгээ хийхийг зөвшөөрсөн болно.

Гарын үсэг

Хуулийн байгууллагын гарын үсэг(насанд хүрээгүй хүүхдүүдэд)

Та хэрэв хэрэгцээ гарвал судсаар тариа тариулахыг зөвшөөрч байна уу

тийм

үгүй